

ОРХОН АЙМГИЙН УС ЦАГ УУР ОРЧНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

2026 оны 04 дүгээр сарын 08

Орхон аймаг

Тус тайлан нь төвийн албан хаагчдын ёс зүйн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг хэрхэн дагаж мөрдөх ёстой талаар хууль эрх зүйн ойлголт, мэдээлэл өгөх, олон нийтэд ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлаа тайлагнах зорилготой юм.

ТӨЛӨВЛӨГӨӨ

Орхон аймгийн ус цаг уур орчны шинжилгээний төвийн дэргэдэх "Ёс зүйн дэд хороо" 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр ёс зүйн ажлын төлөвлөгөө боловсруулан төвийн даргаар батлуулж, төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

БАЛТАЙ
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДЭРГЭДЭХ "ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО"

Орхон аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Төрийн албан хаагчдын ёс зүйн мөрдөх, үргэлжлэн сурталчлах, соёл сургааруулах үндэсний хэлтсийн хэлтэст хянгар 2026 оны төлөвлөгөө

2026 оны 01 дүгээр сарын 06 Орхон аймаг



Мэдээллийн үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл	Ажил хэрэгжүүлэх өдөр	Сүүлчийн өдөр	Хүндэтгэл	Хариуцагч	Харгалзах
Төрийн албан хаагчдын ёс зүйн мөрдөх, үргэлжлэн сурталчлах, соёл сургааруулах үндэсний хэлтсийн хэлтэст хянгар 2026 оны төлөвлөгөө						
Төрийн албан хаагчдын ёс зүйн мөрдөх, үргэлжлэн сурталчлах, соёл сургааруулах үндэсний хэлтсийн хэлтэст хянгар 2026 оны төлөвлөгөө						
Төрийн албан хаагчдын ёс зүйн мөрдөх, үргэлжлэн сурталчлах, соёл сургааруулах үндэсний хэлтсийн хэлтэст хянгар 2026 оны төлөвлөгөө						

Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ	Хүндэтгэл, үзүүлэлт, үр дүн, хэмжээ
-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------	-------------------------------------

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
НАУВИЙН БИЛЭГИЙН ДАРГА *[Signature]* Д.ОЮНБААТ
ХЯНАГАЧ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА *[Signature]* О.АЛЦАМБА

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИА СУРТАЛЧЛАН АЖИЛЛАЖ БАЙНА

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв фэйсбүүк пэйж хуудсаар болон <https://orkhon.namem.gov.mn/> сайтаар дамжуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн зүйл заалтуудыг олон нийтэд сурталчлах, төвийн албан хаагчдад таниулах ажлыг хийдэг. Тухайлбал, анхаарч ажил албан тушаалдаа өдөр тутамдаа хэрэглэхэд нь ойртуулж байгууллагын зарим байршилд, нүдэнд тусах газар хэвлэн байршуулсан.



Мөн ажлын байранд мөрдөх дүрэм журам зэргийг байгууллагын самбарт байршуулан ил тод мэдээлж, албан хаагч бүр хүссэн үедээ эргүүлж мэдээлэл авах боломжтойгоор байршуулсан. Түүнчлэн ажлын байранд мөрдөх ёс зүйн талаарх мэдлэг мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээж байна. Зөвхөн албан хаагчид гэлтгүй олон нийтийг соён гэгээрүүлэх, зөв зохистой харилцаанд уриалах байдлаар ажиллаж байна.

СУРГАЛТ

ЭЭРЭГ ХОНОГШИЛ БҮТЭЭЖ СУРЪЯ

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олон "Эерэг хоногшил бүтээх нь" сургалтад 2026 оны 01 дүгээр сарын 12-нд хамрагдлаа. Сургалтыг "Көүч лаб" академийн Мэргэжлийн сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн оролцогчид удирдан чиглүүлэв.

Эерэг харилцаа бүтээхэд

- Анхны сэтгэгдэл маш чухал. Хүн анх уулзахдаа хэдхэн секундийн дотор нөгөө хүнийхээ талаар дүгнэлт хийдэг. Царайны хувирал, харц, ярианы өнгө, биеэ авч яваа байдал нь итгэл төрүүлэх эсэхэд шууд нөлөөлдөг. Сайн анхны сэтгэгдэл нь цаашдын харилцааны суурь болдог.

- Хоногшил төрүүлэх буюу дахин дахин харилцахад таатай мэдрэмж үлдээх нь харилцааг тогтвортой болгодог. Найрсаг, тууштай, хүндэтгэлтэй байдал нь хүнийг аажмаар дасгаж, итгэлцлийг бий болгоно.

Иймээс анхны уулзалтад анхаарал хандуулахын зэрэгцээ дараагийн харилцаа бүрт эерэг мэдрэмж үлдээж чадвал урт хугацааны, чанартай харилцаа бүрдэх боломж илүү өндөр байдаг ажээ. Тиймээс хамт олны уур амьсгал, ёс зүй, харилцаа хандлагад ч эерэг хоногшил маш чухал гэдгийг суралцлаа.



СТРЕССИЙГ ЭЛДЭВЛЭХ УРЛАГ

Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн хамт олон "Стрессийг элдэвлэх урлаг" сэдэвт сургалтад 2026 оны 01 дүгээр сарын 19-нд хамрагдлаа.

Сургалтыг "Көүч лаб" академийн Мэргэжлийн сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн оролцогчид чиглүүлсэн бөгөөд "Минимал аз жаргал" хувь хүний хөгжил, харилцаа хандлагын цогц сургалтын хүрээнд явагдаж буй юм байна.

Бидний амьдралд тохиолдсон таагүй үйл явдлыг эерэгээр харах, амжилт болгон хувиргах аргад суралцах нь чухал ур чадвар болохыг онцолсон.

Бид ажил дээрээ ч энгийнээр аз жаргалыг бүтээх бүрэн боломжтой бөгөөд ёс зүйтэй эерэг хамт олон байхын тулд хувь хүн бүр бяцхан хичээл зүтгэл гаргахад хангалттай аж.



ТАЛАРХАЖ СУРЦГААЯ

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олон "Талархал" сэдэвт сургалтад 2026 оны 02 дугаар сарын 11-нд хүүхдүүдийн хамт хамрагдлаа.


Сургалтыг "Насан туршийн суралцахуйн төв"-ийн багш Н.Лхагвадулам удирдан чиглүүлж, талархлын ач тусын талаар, талархаж сурах нь эерэг сэтгэл зүйг төлөвшүүлдэг талаар тайлбарлаж, дасгал ажиллуулав.

Талархлын шинж чанар нь амьдралд талархах гүн гүнзгий мэдрэмжийг мэдрэх болоод илэрхийлэхэд оршдог. Одоо байгаа бүх зүйл, орчин, хүрээлэл, найз нөхөд, гэр бүл зэрэг бүхий л зүйлээ хүлээн зөвшөөрч, тэднийг эергээр харж хайрлан баярлах сэтгэл болоод илэрхийлэх сэтгэлийг талархал гэж хэлж болох юм.

Түүнчлэн Талархал дэвшүүлдэг, талархал хэлдэг, талархдаг хүн өөрийнхөө амьдралд үргэлж талархаж байх нь сайн сайхан зүйлүүдийг илүү ихээр үүсгэж байдаг. Талархаж эхэлснээр амьдралаас авах сэтгэл ханамж нэмэгдэж, биеийн тамираар хичээллэх нь нэмэгдэж мөн архи тамхи хэрэглэх нь хүртэл багасдаг гэсэн тооцоо байдаг аж.

Бусдад баярласан талархсанаа илэрхийлэх нь таныг аз жаргалтай болгож оюун санааны хувьд эрүүл, эерэг хандлагатай нэгэн болоход тусалдгийг олон

судалгаагаар тогтоосон байда. Хамт олон, найз нөхдөдөө болон гэр бүлдээ гээд бүгдэд талархаж сурцгаая.



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ БА ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙ

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олон “Хүний хувийн мэдээлэл хамгаалахад анхаарах асуудлууд”, “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай” сэдэвт сургалтуудад 2026 оны 03 дугаар сарын 16-нд хамрагдлаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалахад хувийн мэдээллийг аюулгүй хадгалах, дамжуулах механизм, нийгмийн сүлжээнүүд болон бусад платформуудын аюулгүй байдал, үндэсний болон олон улсын хууль, журамд нийцэж ажиллах шаардлагатай. Түүнчлэн албан хаагчид өөрийн хувийн мэдээллийг яаж ашиглаж байгааг хянах, шаардлагатай бол устгах, засах эрхтэй байдаг. Үүнийг ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулах боломжтой.

Мөн сургалтаар Хүний эрх хамгаалагчид нь хүний эрх, чөлөө, эрхийн зөрчил, зөрчилдөөн, мэдээллийн нээлттэй байдал, шударга ёсны асуудлуудыг дэмжих, хамгаалах зорилгоор ажилладаг хүмүүс, байгууллагууд бөгөөд тэдний эрх зүйн байдлыг олон улсын болон дотоодын хууль тогтоомж, стандартуудад тодорхойлсон гэдгийг санууллаа. Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа нь нийгмийн хөгжил, шударга ёс, ёс зүй, хүний эрхийн хүрээнд холбогдох хуулийг сахихад чухал үүрэгтэй юм.

ЁС ЗҮЙ


Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв нь Байгаль орчны салбар бөгөөд судалгаа шинжилгээний байгууллага юм. Тэр ч утгаараа олон нийтэд байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ёс зүйг төлөвшүүлэх үүрэг хүлээн ажилладаг.

Тиймээс албан хаагчид энэ талын мэдлэг мэдээлэл авах сургалт, хэлэлцүүлэг үйл ажиллагаанд байнга хамрагдан олж авсан мэдлэгээ олон нийтэд түгээх, үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжүүлэх замаар мэргэжлийн ёс зүйг дээдлэн ажиллаж байна.



1. ДЭЭД ГАЗРЫН БОЛОН ОРОН НУТГИЙН БОДЛОГО ШИЙДВЭР

Орхон аймгийн Засаг даргын тамгын газар, ИТХ зэрэг орон нутгийн бодлогын байгууллагаас хэрэгжүүлж буй ёс зүйн заавар зөвлөмж, бодлого шийдвэр, Засаг даргын захирамж, ИТХ-ын тогтоол зэргийг мөрдөх, албан хаагчдад танилцуулах, олон нийтэд түгээх зэргээр хамтран ажиллаж байна.



ЁС ЗҮЙТЭЙ ГЭР БҮЛ

Төрийн албан хаагчийн ёс зүй гэдэг ажлын байраар хязгаарлагдахгүй. Гэр бүл олон нийтэд гээд хаана ч ёс зүйгээр үлгэр дуурайлалтай байх ёстой. Тэр ч утгаараа гэр бүлийн харилцаанд ч ёс зүйтэй байхыг албан хаагчид, олон нийтэд уриалан ажиллаж байна. Түүнчлэн Орхон аймгийн Засаг даргын санаачлан хэрэгжүүлж буй “Бүх хайраа гэр бүлдээ” аяныг Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв дэмжин ажиллаж байгаа юм.

Ёс зүйтэй албан хаагч ёс зүйтэй гэр бүлийг төлөвшүүлж, ёс зүйтэй иргэн хүнийг төрүүлнэ. Тиймээс хүүхэд хүмүүжлийн зэрэг аргууд, харилцааны ёс зүй, хүүхдийн эрх зэргийг сурталчлан, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж байна.




ЁС ЗҮЙ ХАБЭА

Хөдөлмөрийн аюулгүй байдал нь албан хаагчийн сэтгэл зүйтэй шууд хамааралтай. Тиймээс ажлын байранд ажилдаа бүрэн төвлөрөх, аюул осолгүй ажиллах боломжийг хангах үүднээс албан хаагчдын хоорондын харилцаа хандлага, ёс зүйг эерэг байлгахад анхааран ажиллаж байна. Аймаг орон нутгаас санаачлан явуулж буй сургалт хэлэлцүүлэгт албан хаагчдаа түлхүү хамруулахын зэрэгцээ, дотооддоо сургалт, ярилцлага санал асуулга зэргийг нэвтрүүлэн ажиллаж байна.



ЯЛГАВАРЛАЛГҮЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Төрийн албан хаагч нь иргэд олон нийтэд эрх тэгш, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлж, олж авсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллээ задруулахгүй байх үүрэгтэй. Төрийн албан хаагч нь Монгол улсын үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, ёс зүйн дүрэм журмаа ягштал баримтлах ёстой. Тэр ч утгаараа төрийн албан хаагчдад болон олон нийтэд чиглэсэн постер мэдээллийг байгууллагын социал хаягаараа дамжуулан түгээн ажиллаж байна.



БИЕЭ ЗӨВ АВЧ ЯВАХ ЁС ЗҮЙ

Төрийн албан хаагч нь гудамж талбай, нийтийн эзэмшлийн газарт биеэ соёлтой авч явж, үлгэр дуурайлалтай байх ёстой. Улмаар нийгэмд ёс зүйтэй хандлага, соёлтой зөв харилцаа бий болоход нэг алхам ойртох юм.

Хүний хөдөлмөрийг үнэлдэг, хууль дүрмээ баримталдаг, бусдад зөв шаардлага тавьдаг, буруу зүйлээ ухамсарладаг, хариуцлагаа хүлээдэг байдлыг төлөвшүүлэх зорилгоор олон нийтэд уриалга пост нийтлэн ажиллаж байна.



АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙН ҮНЭЛГЭЭ ГАРГАЖ БАЙНА

Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн албан хаагчдын ёс зүйг улирал бүр харилцаа, хандлага, хариуцлага, хамт олонч байдал, хувийн зохион байгуулалт гэсэн 5Х үзүүлэлтээр 1-5 оноогоор дүгнэж байна. Дүгнэлтийг албан хаагчид өөр хоорондоо хийдэг бөгөөд хэн нь хэнд, хэрхэн санал өгч дүгнэж байгааг мэдэгдэхгүй байдлаар зохион байгуулж, санал өгсөн хуудсаа тодорхой цэгт хайрцагт хураан авдаг. Ёс зүйн дэд хорооны гишүүд үнэлгээний хуудсыг албан хаагч бүрийнхээр нэгтгэн авч дүгнэж байна.

№	Урс нэр	Харилцаа	Хандлага	Хариуцлага	Хамт олонч байдал	Хувийн зохион байгуулалт	Урсны дүн
1	С.Сүхбаатар	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
2	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
3	Д.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
4	О.Хандмаа	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
5	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
6	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
7	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
8	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
9	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
10	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
11	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
12	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
13	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
14	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
15	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
16	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
17	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
18	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
19	С.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000
20	М.Оюунбат	12.000	12.000	12.000	12.000	12.000	72.000

Тайлан гаргасан: Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга *Д.Оюунбат* Д.Оюунбат
Хянасан: Ёс зүйн дэд хорооны дарга *О.Хандмаа* О.Хандмаа